



1987 онд ЗХУ-ын хоёр удаагийн, ЗОУ-ын гурван удаагийн торийн шагналт, ЗХУ-ын ходолморийн баатар зохиолч В.Астафьевийн “Гунигт явдал” роман хэвлэгдэн гарч, социалист систем даяараа шуугиж билээ. Соц системийн нэгэн бүрэлдхвн хэсэг байсныхаа хувьд Монголчууд ч энэхүү зохиолыг яаравчлан орчуулж, /орчуулагч нь зохиолч, сэтгүүлч, орчуулагч Р.Ганбат/, тухайн үеийн сэхээтнүүд энэхүү номын талаар энд тэнд хэсэг бүлгээрээ хэлэлцэн мэтгэлцэж, мухардалд орсон соц системийн мон чанарын тухай, гарах гарцын тухай эргэцүүлэн шүүж байлаа... Энэ завсар монголын зохиолчид ч зүгээр байсангүй, тухайлбал С.Жаргалсайхан, Ц.Балдорж, С.Доржготов нарын зарим бүтээлд соц системийн дотоод зорчлийн мон чанарыг нээн үзүүлэх гэсэн оролдлогууд гарч ирж, “Цог” сэтгүүл болон бусад хэвлэлээр оргон хэлэлцүүлэг ч орнож байв.

Үүнээс омнохон ЗХУ-н ходолморийн баатар, ЗОУ-ын торийн шагналт зохиолч Валентин Распутины “Твймэр” тууж монгол хэлээр орчуулагдчихсан байв. /Орчуулагч нь олон улсын тоймч, орчуулагч Ц.Даваажав/. Чухам энэ багавтархан тууж л Горбачевийн эхлүүлсэн “Оорчлон байгуулалт-шинэ сэтгэлгээ” зайлшгүй хэрэгтэй болохыг олон түмний сэтгэл зүрхэнд гарцаагүй шивнэн огвүүлж, соц системийн доторх яагаад ч аргалшгүй болсон зорчлийг нээн үзүүлсэн байна... Хүний натур чанарт оорчлолт дэвшил гараагүй тохиолдолд оюун санааны эзэнт гүрнийг цогцлоон босгох боломжгүй, ямар нэгэн “Твймэр” гарахад л соц системийн доторх хувьдсийг хооронд нь холбож байсан “соц хайр сэтгэл”-ийн хэлхээ холбоос ямар сул хэврэг, хиймэл хоосон, ёс зүйн үүрэг хариуцлага нь ямар ч үнэ хүндгүй болох нь харагдаж, тас тас үсрэн унаж байгааг харуулсан... Үнэхээр ч тийм байсныг дараахан нь орносон түүхэн үйл явц, соц системийн задрал бүрнээ нотлон харуулсан “ГУНИГТ ЯВДАЛ” болсон билээ.

Чухам “Твймэр”, “Гунигт явдал” хэмээх энэ хоёр багавтар тууж Соц системийн мухардлын үнэн дүр торх, мон чанарыг таниулж, ард түмний нүдийг нээж огсон нь оорчлон байгуулалтын дотоод нэгэн чухлаас чухал ходолгогч ходолгүүр болсон ба харин гадаад хүчин зүйл нь огт оор утга агуулга, зорилготой байсан юм. Энэ нь оноодрийн манай сэдэв биш тул түр орхив. А

Уран зохиол гэгч нийгмийн оюун санаанд ямархан их үүрэгтэй болохын ойрмогхон боогоод бидний амьдралтай хамгийн хамаатай, үр дүнг нь бодитойгоор мэдэрсэн жишээ энэ. А

Жаахан омнох үеийн нэгэн тод жишээ авая. 1850 онд АНУ-ын конгресс “Оргодол боолын тухай хууль”-ийг батлан гаргажээ. Энэ хуулиар эзнээсээ оргосон боолыг хатуу чанга

шийтгэнэ. Тухайн вед боолчлолын нохцол байдал хvнд байсан омнод мужуудаас боолууд олноороо оргон, умардын аж вйлдвэржиж эхэлсэн хотууд руу амьдрал хайн дvрвэдэг байжээ. Тэдний эсрэг гаргасан хууль. Оргодол боолыг ангуучилдаг буутай, внэрч нохойтой ангуучдын хвчирхэг баг ихэд моодонд орж байсан гэдэг. Тэд хоорхий оргосон боолыг бууны сvмбээр нохой шиг занчиж, томор гав зvвж, гахайтай хамт хонуулах нь ердийн взэгдэл байж... Алчихад их сайндаа эзэнд нь таван доллар толно. Тухайн вед АНУ-д хар боолын зах зээл ид байсан ve.Â

Энэ байдалд сэтгэл шимширсэн нэгэн эх боолын энэхvв хvнд хэцvв, гашуун хувь тавилангийн тухай зохиол бичжээ. “Том авгын овоохой” гэх энэхvв зохиолыг манай ахмад орчуулагчид аль 50-иад оны вед эх хэлээрээ орчуулан гаргасан санагдана. 1851 оны эхээр тогтмол хэвлэлvвдэд цувралаар гарсан энэ зохиол жилийн дараа бие даасан ном болон хэвлэгдэж, хоромхон зуурт эхлээд 5000, дараа нь бvр 300 000 ширхэгээр зарагджээ. Тэр вейн Америкт 300 000 ширхэг ном гэдэг асар том тоо... Ном дахиад, бас дахиад хэвлэгдэв. Тvвнээс ч хачирхалтай зvйл болсон нь Боолчлолыг эсэргvвцсэн умард, дэмжсэн омнод хоёр талд Америк орон хуваагдаж, улмаар иргэний дайны гал дvрэлзэн асчээ.Â

1862 оны 11 сарын 25-нд Еронхийлогч Абрахам Линкольн Цагаан ордонд Бичер Стоу-г хвлээн авч уулзахдаа “Энэ аугаа их дайны галыг асаасан гайхамшигтай номыг зохиогч тэр бяцхан эмэгтэй та мон гэж вv?” хэмээн дуу алдаж байсан гэдэг.

Ер нь хvн торолхтний тvвхэнд уран зохиолын хвчирхэг нолоотэй эгнvвлж харьцуулах салбар гэж vгвй юм. Бvвр эрт цагт Эртний Грект хвчирхэг тор улс вvсэж, Афины ардчилал мандаж, Спартууд эр зоригоо гайхуулж байв. Гэвч Хомергvйгээр, тvвний “Илиада, Одессиа”-гvйгээр ийм зvйл болох боломжгvй байсан. Яагаад гэвэл Афинчууд бvгд найрамдах улсын взэл санаагаа Хомероос авч, Спартчууд эр зоригоо Хомероор тэжээлгэж байв.

1762 онд шил дараалан хэвлэгдсэн Ж.Ж.Руссогийн “Эмили” роман, “Нийгмийн гэрээ” хоёр нь Францын аугаа их хувьсгалын угтал, оюун санааны хорс суурийг бvрдvвлж огсон гэж вздэг.

Энэтхэгийн вндэсний сэргэн мандал, тусгаар тогтнолын удирдагч, оюун санааны эцэг Махатма Ганди оорийн цохрошгvй, шантрашгvй, эвлэрэшгvй боловч энэрэнгvй их тэмцэл, оюун сэтгэлгээнийхээ эх ундаргыг “Рамаяна”-гаас авч байсан ба тэнгэрийн орноо одохынхоо омно уруул ходолгон шивнэсэн сvлчийн вг нь РААМА байсан гэдэг. Оороор хэлбэл Энэтхэгийн хвч хэрэглээгvй вндэсний их хувьсгалын взэл санааны эх сурвалж нь бидний хэлж заншсанаар “Раамын влгэрийн цоморлог” байж...

Дундад эриний балар харанхуйн хошгийг Дон Кихотын урт чоргор гар сохож, Шекспир тайзан дээр тэр хошгийг бvрэн дэлгэн хаяж, Бальзакаас Европ дахин эдийн засгийн системийн язгуур шинжээ олж харан, Шиллер, Готе, Гэгель, Маркс нар бодомж болгон боловсруулж, тэгээд оюун санааны энэхvв баялаг хорс суурин дээр хогшин Европ хвчирхэгжин ондийж байв. Тэр вейн Барууны ертонцийн мундагчуул болох Бальзак, Флобер, Стандель, Мопассан, Драйзер... Тэд уран бvтээлдээ, романууддаа амьдарч асан нийгмээ бvхий л талаас нь задлан шинжилж, дvгнэн цэгнэж, тэгээд эрс хатуу эсэргvвцэн шvвмжлэгчид байв.Â

Яагаад гэвэл нийгмийн аливаа хогжил дэвшлийн суурь нь оюун санаа байдаг, чухам оюун санаанд ямар нэгэн юм орнож, бужигнаж, эрж хайж, танин мэдэж байж л дараа нь нийгмийн дэвшил бий болдог нь тvвхэн зvй тогтол... Тэр оюун санааны эрч хвч, тэжээл гэрэл гэгээ, унал сэхэлийн нэгэн ундарга нь урлаг, уран зохиол болж ирсэн нь ч мон л

звй тогтол... Уран зохиол бол нийгмээсээ шууд болон шууд бус хамааралтай цэвэр нийгмийн вэзгдэл, хичнээн цэвэр субъектив бvтээл туурвилаа ч тэр туурвигч нь оороо тухайн цаг веййнхээ, нийгмийнхээ бvтээгдхvн л байдаг гарцаагвй хууль бий. Марианы хонхорт торж, Саран дээр осож, Ангараг гариг дээр л боловсрол эзэмшээгвй тохиолдолд шvв дээ. Ямар ч эрхэм дээд цэвэр уран зохиолч нийгэм, цаг веййнхээ золиос нь, бvтээл нь, урлаг нь, нулимс нь, бас дуу хоолой, цуурай нь л байна.Â

Тиймээс ч ухаарч сэхээрсэн хvчирхэг тортэй улс вндэстнvвд уран зохиолын соён гэгээрvлэх, сэхээрvлэх вvргийг онцгойлон анхаарч, бvхий л боломжоороо ашиглахыг хичээдэг.

Энэ хvчирхэг нолоог оорийн вээл суртлын, оюун санааны мороодлийн их улс байгуулах вйлстээ хэрхэн ашиглахаа В.И.Ленин тов тодорхой харж байсан байдаг. Тэрбээр 1914 онд бичсэн “Намын байгууллага ба Намч утга зохиол” бvтээлдээ нийгмийг машин механизм гэж вээх юм бол утга зохиол бол тэр механизмын эрэг шураг нь гэж тодорхойлж байв. Тэр утга зохиолыг оорийн эзэнт улсынхаа эрэг шураг, боолт болгож чадсан. Мон Их Толстойг “Оросын хувьсгалын нэвтэрхий толь” хэмээн нэрлэж байлаа. Үнэхээр ч Их Толстойн бvтээлвдэд тэр цагийн Орос орны нvвр царай, мон чанар нь мохол сэхэл, итгэл мороодолтэйгээ тодоос тод тольдогдон байсан. Энэ бvхэн утга, уран зохиолын нийгмийн вр нолоо, ач холбогдол ямар хvчтэйг харуулна.

1990 оноос омнохон утга зохиол чухам хvйтэн дайны нэгэн гол зэвсэг нь болж байв. Соц систем нь системээ хамгаалж влдэхийн тулд чардайтлаа тэмцэж, утга зохиолын намч, ангич, ардач чанарт байдгаараа анхаарч байхад ногоо талаас нь энэ системийг сохрvлж авах гэсэн хvчин ч улайран, энэ улайралдаа утга зохиолыг ч оргон ашиглаж байв. Нэгхэн жишээ нь ур чадвар, мэргэжлийн тvвшний хувьд овойж оцойх звйлгвй, ядмагхан А.Солженыцины “Гулаг олтриг”-т Нобелийн шагнал хvртэл огч байв. Соц нийгмийн гvнд буй муу муухай бvхнийг осгон мандуулж, гайхан шагшруулж, жигшvлж байлаа. Үр дvн нь ч гарсан.Â

Чухам утга, уран зохиол гэгч зов вйлд, зов хэрэглэх аваас тунчиг сайхан вйлийг бvтээнэ. Харин буруу вйлд, буруу гарт, буруу хэрэглэх аваас ямар ч балаг балчиг тарьж мэдэх тийм л хvчирхэг зэвсэг.Â

Харин 1990 оноос хойш нэг хачирхалтай, согогтой вээл манай уран зохиолын ертонцод тvгээмэл дэлгэрсэн нь нийгмийн шинж чанараас ангид “цэвэр уран зохиол”-ын тухай вээл. Уран зохиолд нийгмийн шинэ чанар гэж байх ёсгвй, зохиолч, уран бvтээлч хvн нийгмийн омно, хэлний омно, ард тvмний омно ямар нэгэн хариуцлага хvлээх ёсонгвй гэсэн вээл... Үзэл ч гэж, тоорогдол, туйлшрал юм.Â

25 жилийн омно урлаг, утга зохиолд байсан намч, ангич, ардач чанарыг таягдан хаях хэрэгтэй байсан, угаасаа тэр бол зохиомол, хиймэл звйл, цаг зуурын чимэг зvлт байсан. Харин утга зохиолын нийгмийн чанарыг нь, улс вндэстний оюун сэтгэлгээний суурь болж байдаг мон чанарыг нь яагаад ч авч хаях боломжгвй. Уран бvтээлч хvн вндэснийхээ хэлний омно, тvвгээр дамжуулаад вндэснийхээ оюун сэтгэлгээний омно, бас цаашлаад улс орныхоо сэргэн мандлын омно томоос том хариуцлага вvрч байдаг. Энэ вvрэг хариуцлагыг намч, ангич, ардач чанартай хольж хутгаад хогтой зуурч болохгвй.Â

Соц вээл сурталтай зохиолыг “Пий, паа” хэмээн тvлхэж, вээл сурталгвй цэвэр уран зохиолын тухай сайхан ярих атлаа жинхнээсээ нул барууны туйлширсан либерал вээл суртал болсон Айн Рэндийн “Атлантын нуруу тэнийв” зохиолыг “Миний ширээний ном” хэмээн всээ сvгсэгнvлэн толгойгоо сэгсчиж, шvлсээ всчvлэн шогширно. Охоордмоор ч юм шиг.

Танин мэдvвлэх, соён гэгээрvвлэх vврэгvй уран зохиолыг бvтээх тухай шогшрон чухалчлах атлаа Жорж Орвелийн “Амьтны ферм”-ийг гайхан шагшрах... Гэтэл гажуудсан нийгмийн мон чанарыг гахайн Ферм дээрх дэг журмаас, дарангуйлагчийн араншинг Удирдагч гахайнаас олж харцгаана... Хоорхон гэдэг нь.

Иймэрхvв гэнэн тоорогдлийн vр дvнд манай vндэстний утга зохиол ард тvмний оюун сэтгэлгээний чинадад, нийгмийн гvнд орнож буй вйл явцыг задлан шинжилж, дэлгэн vзvүлдэг, танин мэдvүлдэг, сэхээрvүлдэг чадвараа бvрэн алдсан.Â

Манай уран зохиолчдын нэг хэсэг нь их сайндаа “Болор цом”, “Утгын чимэг” гэх мэтийн уралдаан тэмцэлдээнд уран яруугаар уншиж, зvрх нь хоорсон олны алга ташилтаар тэжээгддэг шvлгэнцэр, огvүллэнцэрээс цааш гарч чадахгvй байна. Хараагаад, цээрлэж жийрхээд байдаг соц вейнхээ нуль уриа лоозон болсон хоосон цулгай бvтээлvүдээс огтхон ч дээрдэх юмгvй байна. Тvүнээ утга зохиолын хэмжvүр гэж оорсдоо ч итгэцгээж, ард тvмнээ ч итгvүлэн тооролдvүлж, мунхруулж байна. Дотоод эрчим хvч, оюуны тэсрэлт, тэмvүлэлгvй, хий хоосон гунигласан, нялагнасан, vгээр наадсан, яг л онгоор угалзлуулсан авдрын хээ шиг шvлгэнцэрvүдээс, утга авцалдаа, тvүхэн vнэн, ур чадвараас нэлээд хол тосоо романцаруудаас хэтэрч чадахгvй байна. Нэг бол олны анхаарал татсан сэдвээр бизнес хийж, эсвэл шалдар сулдар сэдэв тойрон гунганалддахаас хэтрэхгvй байна.

Арай домогхон ногоо хэсэг нь “Цэвэр уран зохиол”-ын тухай сэршгvй гvн бат зvүдэн нойрондоо умбацгаажээ. Эргэн тойронд нь юу болж, ард тvмэн нь юунд баярлаж, юунд хоорч, юунд гутарч, юунд зовж шаналан, юуг хvсэж мороодож буйг анзаарах ч сохоогvй, цэвэр утга зохиолынхоо тухай аугаа их мороодлийн зvүдэндээ мансуурцгаажээ. Хvйтэн дайнд ялагдаж явсан тэр цаг вeд хvйтэн мэсэнд vхлийн мэт гvн гvнзгий шарх авчээ.Â

Энэ цаг вe бол нэн сонирхолтой цаг вe, хvн болоод тvүний мон чанар, нийгэм болоод тvүний олон хувилбарыг таньж мэдэх боломж уран зохиолчдод нэн оргон нээж огсон цаг вe. Алах ял заагдан шонд дvүвлvүлж, цоллогт хатаж, олсголон, орд таталдаж явсан Ф.Достоевский хэцvү бурангуй тэр цаг вeэ “Энэ цаг вeд торсон минь юутай аз вэ” гэж халаглан бичиж байсан нь чухам тvүнд тэр хэцvү цаг вe нь хvн, тvүний мон чанарыг танин мэдэхэд ямар ч номоос, эрдэмтнээс, гvн ухаантнаас илvү багшилж байсанд оршино.Â

Манай энэ цаг вeд чухам энэ л цаг вейнхээ, энэ нийгмийнхээ, ард тvмний оюун сэтгэлгээний гvнд болж буй вйл явдлыг задлан шинжилсэн, нээн vзvүлсэн уран зохиол нэн хэрэгтэй байна. Яагаад гэвэл, оноодор, Монгол Улсад нийгмийн томоохон хогжил дэвшил зайлшгvй хэрэгтэй цаг вe, оороор хэлбэл оюун санааны их хувьсал оорчлолтийн цаг вe тулж ирээд байна. Харин тэр цаг вейг урин дууддаг тvүчээ нь, Данко нь болсон эрхэм уран зохиолчид, оюун билиг, сэтгэлгээний их мастерууд маань хаана байна? Том эргэлтийн, дэвшлийн оюуны суурийг тавьдаг тэр хvмvүс маань хаачив... Монголын Бальзак, Толстой нар...Â

Нийгэм харанхуй мунхаг болох хэрээр, зэрлэгшиж, задрах хэрээр, нийгмийн хогжил гажих хэрээр утга зохиол цэвэршдэг тийм теором ч гэж байхгvй. Хэрвээ тэгдэг ахул утга зохиолын ч хэрэг алга.Â

“Болор цом” зvүдлэн зvүдлэх сайхан зvүднээсээ сэрцгээ, эрхэм Болор цомтонгууд аа... Улс орон чинь уруудан доройтсоор нэг л мэдэхэд мороодол болсон Болор цом чинь Зоос зуусан ногоон мэлхийгээр солигдчихвол яах гээ вэ?

“Зvүлгэн дээр гэрээ бариад Зvгээр л нэг амьдрахсан” хэмээн зvүдлэх сайхан зvүднээсээ сэрцгээ, Яруу найрагчид аа... Газар шороо чинь цолмvүлэн ухуулсаар, цолжиж, гандсаар

нэг л одор гэрийн буурийн чинээ ч звлэг олдохгvй болчихсон байх ахул ямар баллад,
риквиемээ бичих гээ вэ?Â

“Цэвэр уран” зохиол зvдлэн зvдлэх сайхан зvднээсээ сэрцгээ, Уранзохиолчид оо... Эх
оронгvй, эх хэлгvй, элгэн ард тvмэнгvй болчихвол эзгvй цолд очиж элсний ширхэгэнд
шvлгээ уншиж, vнс нурманд зохиолоо шивнэж огох гээ юу?

Б.Номинчимэд

2015.2.28

Â Â Â Â Â Â Â Â